

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2023/05

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.V	2022.V	2023.IV	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 1-р улирал	их наяд ₮, оны үнээр	-	-	13.6	-	-	-	7.9% ▲
Инфляц	хувь	11.3%		11.3%	1.3% ▲	-	6.1% ▲	-3.8% ▼ нэгж хувиар
Ажилгүйдлийн түвшин	хувь	-	8.5% 2022 оны У1	6.6% 2023 оны У1	-	1.3% ▲ нэгж хувиар	-	-1.9% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1395.3	-539	1099.6	296 ▲	-	-	1934 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3461.18	3110.22	3496.41	35.23 ▼	-	-	350.96 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	2842.9	946.5	2423.4	419.5 ▲	-	-	1896.4 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	23.9	5.7	19.6	-22% ▼	-	-	4 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	630.3	611.2	483.3	-22% ▼	-	-	3% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	10%	13%	0%	-	0%	3% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.89		3.69	6% ▲	-	-	25% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	9.20%	9.10%	9.66%	0.46% ▼ нэгж хувиар	-	-	0.09% ▲ нэгж хувиар

ОНЦЛОХ СТАТИСТИК:

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ТАНИЛЦУУЛЛАА	Монгол Улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр тайланд хамрагдсан 64 улсаас 62-т эрэмбэлэгджээ. Нийт 100 оноо авахаас 35.56 оноотой байна. Энэ нь өмнөх оноос 0.64 оноогоор буурч 1 эрэмбэ ухарсан үзүүлэлт юм.
НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ ӨНГӨРСӨН ЖИЛЭЭС 4.2 ДАХИН ӨСӨВ	2023 оны 5-р сарын байдлаар Монгол Улс өнгөрсөн жилээс 4.2 дахин их хэмжээний нүүрс экспортлосон ч гэлээ бодит орж ирж буй орлого ердөө 2 дахин өссөн байсан. Учир нь 2022 оны энэ үед 1 тонн нүүрсний үнэ 300 ам.доллар орчим байсан бол 2023 онд 150 ам.доллар орчим болж нүүрсний үнэ 2 дахин буурсан байна.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
1. ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙВ	2023/06/16	2023 оны төсвийн орлого 1,7 их наядаар давж биелсэн тул Монгол Улсын Их Хурлаар төсөвт тодотголыг баталж, цалин тэтгэвэр нэмэх, хүүхдийн мөнгийг хүсэлт гаргасан хүүхэд бүрт олгох, нийслэлийн түгжрэлийн асуудлыг шийдэж байна.
2. ТӨВ БАНК МӨНГӨНИЙ ХОРОО ХУРАЛДАВ	2023/06/23	Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 5 дугаар сарын 31 болон 6 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 5 дугаар сард өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 5 дугаар сард 3461.18 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 350.96 төгрөгөөр чангарсан бол, өмнөх сараас 35.23 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 6%-иар өсч, 3.89 тэрбум ам.долларт хүрээд байна.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 9.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 (37.5%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 8.5 их наяд төгрөг болж, 2.6 (43.2%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 оны эхний 5 сард 7.1 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний 5 сард нийт 139 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9.8 тэрбум америк доллар, үүнээс экспорт 6.3 тэрбум америк доллар, импорт 3.5 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.5 (35.3%) тэрбум америк доллароор, экспорт 2.2 (54.4%) тэрбум америк доллароор, импорт 325.7 (10.4%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2023 оны 5 дугаар сард экспорт өмнөх сараас 98.7 (7.5%) сая америк доллароор буурч, импорт 81.5 (11.3%) сая америк доллароор өссөн байна.

Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.
Эх сурвалж: Олон улсын валютын сан
- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа
Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 5-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 5-р сар 2023 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.mongolbank.mn